




CFLI/FCIL

Орон нутгийн санаачилгыг
дэмжих Канад сан



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

СОНГОГЧИЙН ГАРЫН АВЛАГА



I. УИХ ГЭЖ ЮУ ВЭ, ЮУ ХИЙДЭГ ВЭ?

II. УИХ-ЫН ГИШҮҮНЭЭС ЮУ НЭХЭЖ БОЛОХ ВЭ?

III. ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ
ИРГЭДИЙН ОРОЛЦОО

IV. СОНГУУЛЬ ЯГ ШУДАРГА ЗОХИОН
БАЙГУУЛАГДДАГ УУ?

V. СОНГОГЧДЫН САНАЛЫГ УИХ-Д ХЭРХЭН
ХУВААРИЛАХ ВЭ?

VI. ӨӨРСДИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ СОНГОХ
ШИЙДВЭР

VII. ХУУРАМЧ, ТӨӨРӨГДҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛ,
МАНИФУЛЯЦАД АВТАХГҮЙ БАЙХ

VIII. СОНГОГЧДЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

IX. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН АЧ
ХОЛБОГДОЛ



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



CFLI/FCIL

Канад сангийн Орон
нутгийн санаачилга

I. УИХ ГЭНН ЮУ ВЭ?

ЮУ ХИЙДЭГ ВЭ?





Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал (УИХ) бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ-д хадгална” гэж заасан байдаг. УИХ нь хууль тогтоох бүрэн эрхтэй, төрийн эрх барих дээд байгууллага юм.

* Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хуулиас



Үндсэн хуульд 2023 оны тавдугаар сарын 31-нд өөрчлөлт оруулсан. Ингэснээр УИХ нэг танхимтай, 126 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар болсон. 2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийн үр дүнд 126 гишүүнтэй ажиллах анхны УИХ бүрдэх юм.


* УИХ-ын ээлжит сонгуулийг 2024 оны 6 сарын 28-нд зохион байгуулна.



Ард түмэн сонгуулиар сонгож байгуулсан төлөөлөгчдийн байгууллага болох УИХ-аар дамжуулан өөрсдийн эрх мэдлээ хэрэгжүүлдэг. Тиймээс иргэд, олон нийт УИХ-ын үйл ажиллагаанд оролцож, байнга хяналт тавих нь зүйтэй.

*Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.

Парламент бол ард түмний төлөөллийн байгууллага юм. Манай улсын бүх хүн цуглаад асуудлыг хэлэлцэж шийдэх боломжгүй учраас өөрсдийгөө төлөөлж шийдвэр гаргах хүмүүсийг сонгодог.



Сонгуулиар бид өөрийгөө төлөөлөх хүнийг сонгодог гэсэн үг. Тэд биднийг төлөөлөх элч, төлөөлөгч бөгөөд тэднийг дарга гэж ойлгодог нь нийгэмд тогтсон буруу ойлголт.



"Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ."


* Улсын Их Хурлын гишүүний тангаргийн үг



УИХ төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, улсын хил тогтоох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд бусад улсаас аюул занал учруулж, зэвсэглэн халдвал дайн бүхий байдал зарлах, цуцлах... зэрэг асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэдэг.



Улсын Их Хурал бол ард түмний төлөөлөл болсон байгууллага учраас нийгмийн янз бүрийн төлөөллөөс бүрдэх нь сайн байдаг. Гэхдээ хэнийг сонгох вэ гэдгийг ард түмэн сонгуулиар шийддэг.



Тэгвэл багш аа Улсын Их Хурал хууль баталдаг гэхээр зөвхөн хуульчид ажилладаг гэсэн үг үү?

Тодруулбал, 18 насанд хүрсэн иргэн УИХ-ын гишүүнийг сонгох сонгуульд саналаа өгөх эрхтэй. Харин 25 насанд хүрсэн иргэн УИХ-ын сонгуульд нэрээ дэвшүүлэх буюу сонгогдох эрхтэй. Гагцхүү хэнийг сонгохыг зөвхөн сонгогч иргэд шийддэг.



Тэгэхээр би ч гэсэн насанд хүрэхээрээ бусдыгаа төлөөлөн нэр дэвшиж болох нь ээ

УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаа нь хуулийн төсөл санаачлахаас эхлээд эцэслэн батлах хүртэлх бүхий л үе шатаас бүрддэг. УИХ-ын чуулганы хуралдаан хууль дээдлэх, нээлттэй, ил тод байх, асуудлыг хэлэлцэхэд чөлөөтэй, эрх тэгш оролцоог хангах, цөөнхийн эрхийг хүндэтгэх, хэлэлцүүлгийн горим ойлгомжтой, тодорхой байх, олонхын саналаар шийдвэр гаргах зарчимд үндэслэнэ.

* УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиас



Пөөх нэг сонгогдчихвол
насаараа УИХ гишүүн байх уу?

УИХ-ын сонгууль дөрвөн жил
тутамд зохион байгуулдаг. УИХ-
ыг үйл ажиллагааны үндсэн
хэлбэр нь чуулган байдаг.



Та нар УИХ-ын хаврын чуулган, намрын
чуулган гэж сонсож байсан л биз дээ.



Аан тэгвэл би намайг төлөөлж
чадах хариуцлагатай хүнд саналаа
өгөх ёстой юм байна.



УИХ бүрэн эрхээ ээлжит болон ээлжит бус чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлдэг. УИХ улсын нийгэм, эдийн засаг, боловсрол, аюулгүй байдал гэх зэрэг тодорхой чиглэл, асуудлаар байнгын, дэд, түр хороодтой бөгөөд УИХ-ын гишүүд эдгээр хороодод хуваарилагдан ажилладаг.

* УИХ-ын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа далан таваас доошгүй ажлын өдөр чуулна.



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



CFLI/FCIL

Канад сангийн Орон
нутгийн санаачилга

II. УИХ-ЫН ГИШҮҮНЭЭС

ЮУ НЭХЭН БОЛОХ ВЭ?



УИХ-ын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. УИХ-ын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.

* УИХ-ын гишүүний бүрэн эрх Төрийн сүлдэнд тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.



Гэр маань ч мууджээ.
Өвлийг яаж давна даа

Тойргийнхоо гишүүнтэй
уулзаад үздэг юм бил үү...

Хэрэв УИХ-ын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг УИХ-ын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болдог бөгөөд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэдэг.

* УИХ-ын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.



Сайн байна уу, гишүүн ээ.
Амьдрал хэцүүдлээ, цалин
хүрэлцэхгүй байна. Манайд нэг
монгол гэр өгөх боломж байна уу?

Сайн, сайн байна уу та.
УИХ-ын гишүүн ийм төрлийн
ажил хийх ёсгүй юм аа.



Юу яриад
байгаа юм бэ.
Би танд саналаа
өгсөн шдээ.

УИХ-ын гишүүд нь:

- хууль санаачлах
- хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан санал хэлэх
- асуулт тавих
- санал хураалтад оролцох
- Хууль ба УИХ-ын шийдвэрийн биелэлтийн талаар мэдээлэл шаардаж авах гэх мэтчилэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ажилладаг шүү дээ.



УИХ-ын гишүүн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл санаачлах, санаачилсан хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг өөрийн саналаар татаж авах, гишүүний ёс зүйн дүрэм, хуралдааны дэгийг чанд сахиж ажиллах бүрэн эрхтэй.

* УИХ-ын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулж бусдаас шан харамж авахыг хориглоно.




УИХ-ын гишүүн төрийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, улсын төсвийг хэлэлцэн батлахад Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан (...Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа ... Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно...) хүрээнд санал гаргах бүрэн эрхтэй.

Тодорхой хэлээд өгөөч,
гишүүн ээ.



УИХ-ын гишүүн бол Монгол Улсын
Их Хурлын тухай хуульд заасан
бүрэн эрхийг л хэрэгжүүлэх ёстой.



Өнөөдөр танд гэр өгч аргацаах бус
хангалттай цалин орлоготой,
худалдан авах чадамжтай нийгмийг
бүтээх нь бидний ажил юм шүү дээ

Хуулиар хүлээсэн эрх үүргээ хэр
ухамсарлаж энэ хүрээндээ ажиллаж
байна уу үгүй юу гэж хардаг бол улс
төрчид бид мөн ч их баярлана даа ах минь.



УИХ-ын гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух, байр сууриа илэрхийлэх, санал гаргах, санал хураалгах, иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан хариу өгөх, эсхүл харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж энэ тухай хариу мэдэгдэх бүрэн эрхтэй.

* УИХ-ын гишүүн хууль бус шийдвэр гаргуулахаар бусдад нөлөөлөхийг хориглоно.



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



CFLI/FCIL
Канад сангийн Орон
нутгийн санаачилга

III. Парламентын үйл ажиллагаа дахь иргэдийн оролцоо



Парламентын үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах нь төлөөллийн ардчиллын үндэс бөгөөд парламентын ардчиллыг төлөвшүүлэх, иргэдийн итгэлийг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй. Тиймээс УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаа нээлттэй, хэлэлцэн баталж буй хуулийн төсөлд иргэд, олон нийтийн оролцоог хангах ёстой юм.



Хууль тогтоомжийн тухай хуульд хууль санаачлагч хуулийн төслийг боловсруулахдаа иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар хуульчилсан байдаг. Тус хуулийн 38.1-т “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана” гэж заасан.



Улстөрч болох нь уу дээ,
миний найз.

Үгүй ээ, Ардчилсан
улсад иргэдийн
оролцоо сайн байж
чадвал төрийн үйл
ажиллагаа сайжирдаг.




За сонсьё оо.


Тиймээс УИХ-ын үйл
ажиллагаанд иргэд хэрхэн
оролцох боломжтой
талаар найз нь хэлж өгье.

Сонгуульд саналаа өгөх нь иргэдийн оролцооны
зөвхөн нэг хэлбэр бөгөөд өөр олон хэлбэр бий.

Нийтийн
өргөдөлд нэгдэх



Үзэл бодлоо
илэрхийлэх



Жагсаал
цуглаанд оролцох



Хуулийн төсөлд
саналаа өгөх

Өргөдөл,
гомдол гаргах

Иргэдийн оролцоог хангах өөр нэг механизм бол **нийтийн сонсголд** оролцох боломж юм. УИХ-аас зохион байгуулах сонсголд иргэд хүсэлт гаргасны үндсэн дээр оролцох боломжтой. Мөн сонсголыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор ажиглагчаар оролцож болно. Нийтийн сонсгол нь ерөнхий хяналтын, нэр дэвшигчийн, хууль тогтоомжийн зэрэг олон төрөлтэй байдаг.

Нийтийн өргөдөлд
яаж нэгдэх вэ?

Нийтийн эрх ашгийг
хөндсөн асуудлаар
санаачилсан цахим
өргөдөлд гарын үсэг
зурж, нэгдэнэ гэсэн үг.

УИХ-ын
d-parliament.mn сайт,
UIN.mn платформд
нийтийн өргөдөл
санаачлах, нэгдэх
боломжтой шүү дээ.



Иргэд тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх талаар асуулт асуух, санал өгөх эрхээ УИХ-ын албан ёсны санал авах цахим хуудас, гар утас, хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан УИХ-ын албан ёсны программ хангамжаар дамжуулан хэрэгжүүлж болно. Үүнийг **нийтийн өргөдөл** гэж нэрлэдэг.

* УИХ-ын D.parliament.mn-ээр дамжуулан иргэд нийтийн өргөдөл санаачлах боломжтой.


Тэгвэл хуулийн төсөлд саналаа
яаж өгөх ёстой юм бол?



Хуулийн эрх санаачлах



Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн болон
Засгийн газар хууль санаачлах эрхтэй.



Иргэд хууль санаачлагчийн
санаачилсан хуулийн төсөлд
саналаа өгөх боломжтой.

Тухайлбал, бичгээр, уулзаж,
хэлэлцүүлэгт нь оролцож, цахимаар
гэх мэтчилэн боломжууд бий.



Нийтийн өргөдлийг 100 мянгаас дээш тооны иргэн дэмжсэн бол тухайн асуудлаар хуулийн төсөл санаачлах боломжтой. Харин 70 мянгаас дээш тооны иргэн дэмжсэн бол Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах санал гаргана. 33 мянгаас дээш тооны иргэн дэмжсэн бол тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах боломжтой.

За за ёстой хэрэгтэй мэдээлэл өгсөн найздаа баярлалаа. Амжилт найз минь оролцоод байж дээ.

Чи ч бас оролцох хэрэгтэй. Чи оролцохгүй бол чиний санал тусгагдахгүй л гэсэн үг шүү найзаа. УИХ-ын үйл ажиллагаанд оролцдог байх нь сонгуульд саналаа өгөхөөс дутахааргүй чухал зүйл юм шүү.



УИХ-ын үндсэн зорилт нь ард түмний төлөөллийн дээд байгууллагын хувьд ард түмний засаглах эрхийг хангахад оршдог. Тиймээс УИХ-ын хянан шалгах бүрэн эрхийн хүрээнд нээлттэй сонсголууд олноор зохион байгуулж, иргэдийн оролцоо, хяналтыг дэмжиж байна.

* УИХ-ын албан ёсны цахим хуудас болох parliament.mn -ээр нээлттэй сонсголуудын тов, зарлалыг түгээдэг.




ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



CFLI/FCIL
Канад сангийн Орон
нутгийн санаачилга


IV. Сонгууль яг шударга зохион байгуулагддаг уу?



Сонгууль зохион байгуулах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний албан тушаалтан, нэр дэвшигч, сонгуульд оролцогч нам, эвсэл, бусад байгууллага, түүний албан тушаалтан сонгууль зохион байгуулах, түүнд оролцохдоо хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих зарчим баримтлах ёстой.



Санал авах байрны хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байранд хяналтын камер байрлуулдаг. Төв суурин газраас алслагдсан баг дахь санал авах байранд хяналтын камер байрлуулж болно. Хяналтын камерыг сонгогч саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахгүйгээр байрлуулж, сонгогчийг бүртгэх болон санал өгөх орчинд явагдаж байгаа үйл ажиллагааг баримтжуулдаг.



Найз нь сонгууль шударга зохион байгуулагддаг гэдэгт эргэлзэж байна. Жишээ нь, сонгуулийн санал тоолох төхөөрөмжийг хакердан, сонгогдоогүй хүнийг их саналтай гэж тоолбол яах билээ.



Яалаа гэж дээ,
найз минь.

Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн санал тоолох төхөөрөмжийн ажиллах горимыг нээлттэй тайлбарладаг.

Итгэхгүй бол өөрийн биеэр тус байгууллагад очоод саналын хуудас хийж, шалгаж үзэж болдог.



Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, эсхүл нэр дэвшигч нь нэг санал авах байранд 2 хүртэл, Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага нэг санал авах байранд 2 хүртэл сонгуулийн ажиглагчийг томилж ажиллуулах эрхтэй. Нэр дэвшигч болон төрийн албан хаагч ажиглагчаар оролцохыг хориглоно.

* Сонгуулийн ерөнхий хорооны байранд очиж, сонгуулийн санал тоолох төхөөрөмжийн ажиллах горимтой танилцахад нээлттэй байдаг.



Сонгуулийг шударга байлгах үүднээс санал авах байранд намуудын төлөөлөл, иргэний нийгмийн ажиглагчид давхар хяналт тавьдаг.



Санал тоолох төхөөрөмжийн дүнг нягтлах зорилгоор гараар хяналтын тооллого ч хийдэг.

Гэхдээ л иргэдийн саналыг намууд, нэр дэвшигчид мөнгө өгөөд худалдаад авчихдаг шүү дээ.



Санал авах ажиллагаа дууссаны дараа бүх хэсэгт хяналтын тооллого хийнэ. Хяналтын тооллого хийх ажиллагаанд ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын болон сонгогчдын төлөөллийг ажиглагчаар оролцуулж болно. Санал тоолж эхэлсэн бол завсарлахыг хориглоно.

Уг нь ч дэмжиж байгаа хүн
бий л дээ. Гэхдээ бидний
хэнд санал өгснийг
мэдчихвэл яах вэ?



Монгол Улсын иргэд саналаа нууцаар
гаргах эрхтэй. Тэрхүү эрхийг хуулиар
хамгаалах бөгөөд тус эрхэд халдсан
үйлдлийг хуулийн байгууллагад өгч
шийдвэрлүүлэх боломжтой. Тиймээс
чиний сонгох эрхэд халдах гэсэн
үйлдлийг шууд мэдэгдэж байгаарай.



Сонгуулийн хамгийн гол зарчим нь саналын нууцлал байдаг.
Тиймээс санал авах байрыг иргэдийн саналын нууцад халдах
боломжгүйгээр зохион байгуулагддаг шүү дээ. Миний найз
сонгуулийн шударга байдалд санаа зоволтгүй.

Сонгогч саналаа нууцаар гаргах ба хөндлөнгийн
нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж саналаа
өгөх боломжоор хангагдсан байх ёстой. Иргэний
сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлах,
сонгогчоос саналаа чөлөөтэй өгөхөд нь
хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг
хориглоно.

* Сонгуулийн ерөнхий хорооны албан ёсны сайтаас сонгуулийн
үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл авах боломжтой.



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



CFLI/FCIL
Канад сангийн Орон
нутгийн санаачилга

V. Сонгогчдын саналыг УИХ-д хэрхэн хуваарилах вэ?



УИХ-ын ээлжит сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. УИХ-ын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.

* УИХ-ын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.



“Олныг төлөөлөх буюу мажоритар арга” гэж тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.



Үлдсэнийг нь яаж сонгох вэ, хүү минь?

Сонгуульд оролцож байгаа улс төрийн нам тус бүр 48 нэр дэвшигчийн жагсаалт үүсгэнэ.



Таны дэмжсэн нам нийт сонгогчдын 30 хувийн саналыг авлаа гэж бодоход тухайн намын жагсаалтад байгаа 48 хүний эхний 30 хувь нь гишүүн болно гэсэн үг юм.



“Хувь тэнцүүлэн төлөөлөх буюу пропорционал арга” гэж сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн авсан саналынх нь тоо, хувьд үндэслэн УИХ-ын сонгуулийн тухай хуульд заасны дагуу суудал хуваарилж, УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцохыг ойлгоно.

* Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ.

Өө тэгвэл өгсөн санал орхигдохгүй, дэмжиж байгаа намд суудал болж очих юм байна.

Тийм ээ, намд саналаа өгнө бас нэр дэвшигчид ч саналаа өгөх юм байна аа өвөө.



Сонгуулийн ерөнхий хороо нь санал хураалтын дүнг үндэслэн тухайн тойрогт нэр дэвшсэн нийт нэр дэвшигчдийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана. Хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцно.



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



CFLI/FCIL
Канад сангийн Орон
нутгийн санаачилга

VI. Өөрсдийн төлөөллийг сонгох шийдвэр



Монгол Улсын иргэн шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох, төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Иргэд Үндсэн хуулиар олгосон сонгох эрхээ хараат бусаар, хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр бие даан шийдвэр гаргаж эдлэх ёстой.

* Үндсэн хуулиас

Сонгууль дөхжээ, улстөрчид
“идэвхжээд” эхэлсэн байна.



Тийм байна. Гэхдээ би л
лав хэнийг сонгох вэ гэсэн
шийдвэрээ бие дааж,
бодитой үндэслэлд
тулгуурлаж гаргана аа.



Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа нууцаар гаргахаар хуульчилсан байдаг. Сонгогч санал авах байранд иргэний үнэмлэхтэйгээ очиж, саналаа биечлэн өгнө. Сонгогч саналын хуудаст бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө.

* Сонгогч гэж сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг хэлнэ.



Мөрийн хөтөлбөр үү?



2024
2020
2016




Мэдээж мөрийн хөтөлбөр чухал. Гэхдээ өмнө нь дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөө хэр зэрэг хэрэгжүүлсэн бэ гэдэг ч чухал.



Үүнээс гадна нэр дэвшигчдийн ёс зүй, өмнө нь авлига болон аливаа асуудал, гэмт хэрэгт холбогдож байгаагүй зэргийг нь харгалзан үзнэ.

Сонгогч саналын хуудаст саналаа тэмдэглэх үед тухайн сонгогчийн дэргэд өөр хүн байхыг хориглодог. Харин эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон боловсролын түвшнээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар саналаа өгөх боломжтой байхаар хуульд заасан.

Яаж түүнийг нь мэдэх вэ?



Олон талын баттай эх сурвалжид тулгуурлан, өөрийн хэмжээнд тодорхой судалгаа хийнэ.




Улс төрийн намыг нь судлах бас чухал юм биш үү?



Тийм. Өрсөлдөгчдийг хооронд нь харьцуулах, нэр дэвшигчдийн боловсрол, туршлага, хандлага, улс төрийн намын бодлого гээд бүх зүйлийг нь харах ёстой.

Сонгогч нэр дэвшигчийн болон улс төрийн нам, эвслийн мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийн мэдлэг боловсрол, ажлын туршлага, ёс зүй, амлалт, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлсэн байдлыг олон талын эх сурвалжаас судлан, санал өгөх өөрийн шийдвэрээ гаргах нь зүйтэй. Жишээ нь, УИХ-ын гишүүнээр өмнө нь ажиллаж байсан бол санаачилсан хуулийн төсөл, хуралдаа суусан байдал, өгсөн санал зэргийг харгалзах нь чухал юм.



Сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг хүртэл аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэхийг хориглодог. Тиймээс сонгогчид үүнээс зайлсхийж, холбогдох хууль хяналтын байгууллагад энэ талаар мэдэгдэх нь зүйтэй.



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



CFLI/FCIL

Канад сангийн Орон
нутгийн санаачилга

VII Хуурамч, төөрөгдүүлсэн мэдээлэл, манипуляцад автахгүй байх



Сонгогч олон нийтийн цахим сүлжээн дэх хуурамч, төөрөгдүүлсэн мэдээллээс зайлсхийж, мэдээллийн дархлаатай байх нь чухал. Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилготой аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах хориотой.



Ээж минь, та цахим хуудсандаа үнэн, худал нь мэдэгдэхгүй ямар их мэдээлэл шэйрлэдэг юм бэ?

Хэрэгтэй юм байна аа хө



Орчин үед мэдээллийн боловсрол маш чухал болсон. Аливаа мэдээллийг уншаад шууд итгэх, бусдад хуваалцахаас урьтаж, нягтлан шалгах хэрэгтэй.

Хэрэв нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараасан бол хуулийн хариуцлага хүлээлгэнэ.


* Үндсэн хуулиар олгосон иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах ёсгүй ч нөгөө талаар хүний хувийн нууц, нэр төрд халдах нь сонгуулийн зарчимд нийцэхгүй.

Яаж нягтлах вэ?

I

Эхлээд мэдээллийн эх үүсвэрийг нь нягтлах хэрэгтэй. Нэр, ус нь тодорхой, итгэж болохоор хүн, албан ёсны хаягаас түгээсэн, эсэхийг нь шалгана гэсэн үг.

Зураг?



НЭР?

- сенсаци?
- үнэн / худал?
- баталгаа?

II

Дараа нь мэдээлэл хэт их уянгын халилтай, эсвэл уур уцаар хүргэхүйц буюу сэтгэл хөдлөл дээр тоглолт хийх агуулга шингээсэн эсэхийг шалгаарай.

Сэтгэгдэл нь яг үнэн үү?

Сонгуулийн үеэр сурталчилгаанд дараах хэлбэрийн цахим хуудас ашиглаж болохоор УИХ-ын сонгуулийн тухай хуульд заасан. Үүнд нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудаснаас гадна цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас, мөн бусад цахим хуудас багтана.

Зураг, видео бичлэгийг
хүртэл хуурамчаар хийх
боломжтой юм уу?

Техник, технологи өндөр хөгжсөн
эрин зуунд энэ нь боломжтой зүйл.
Тиймээс мэдээлэлд итгэх, сэтгэл
хөдлөлд автан бусдад түгээхдээ
хариуцлагатай байх ёстой шүү.



Нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудсыг Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) бүртгэдэг. Бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг хориглодог. Тиймээс нэр дэвшигчийн мэдээллийг авах бол ХХЗХ-ны сайт дахь бүртгэгдсэн цахим хаягнуудын жагсаалтын холбоосоор орж танилцах боломжтой.

MONGOLIAN
FACT CHECKING
CENTER

FACT
CHECK
MONGOLIA



- ✓ Хаяг хуурамч
- ✓ Төөрөгдүүлсэн
- ✓ Баталгааргүй



Аливаа мэдээллийг үнэн,
эсэхийг нягтлан шалгадаг
байгууллагууд бий. Тухайн
байгууллагад хандаж,
шалгуулж ч болно.

Ээ хайрхаан!



Аливаа мэдээллийг худал, эсэхийг нягтлан шалгах боломжгүй бол мэдээллийг нягтлан шалгадаг иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудад хандан мэдээллийн үнэн, эсэхийг тогтоолгох боломжтой. Тухайлбал, Mongolian fact Checking center, Factcheck Mongolia байгууллагыг үүнд нэрлэж болно.



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



CFLI/FCIL
Канад сангийн Орон
нутгийн санаачилга

VIII. Сонгосон төлөөлөгчдийн үйл ажиллагаанд тавих хяналт



УИХ-ын үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчимд нийцсэн, бие даасан, нээлттэй, ил тод байх... зарчимд үндэслэнэ. Тиймээс иргэд сонгогдсон төлөөллийн үйл ажиллагаанд хяналт тавих нь зүйтэй. Хэрэв УИХ-ын үйл ажиллагаа хаалттай (нууцад хамаарахаас бусад асуудлаар) байгаа бол түүнийг нээлттэй болгохыг шаардах эрхтэй.

Саяхан сурталчилгааны үеэр ирж,
уулзаад, иргэдийн асуудал, саналыг
сонсоод байсан хүн чинь УИХ-д
сонгогдоод л “алга боллоо”.




Сонгогдсон төлөөлөгчдөд хяналт
тавих боломжтой юм байна шүү дээ.



УИХ-ын гишүүн хуралдаандаа оролцож
байна уу, ямар хууль санаачилж,
ажиллаж байна вэ гэдгийг UIN.mn
талбар оруулдаг юм байна.



ИРЧ :



ИРСЭН ЧӨЛӨӨТЭЙ ТАСАЛСАН ХОЦОРСОН
МИНЭТ

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлийг
УИХ-ын албан ёсны цахим хуудсанд байршуулж олон
нийт танилцах бололцоог хангахаар хуульчилсан
байдаг. Үүний дагуу нээлттэй байршуулсан чуулганы
хуралдааны тэмдэглэлтэй иргэд танилцах
боломжтой.

* УИХ-ын албан ёсны цахим хуудас болох parliament.mn-д
чуулганы хуралдааны тэмдэглэлийг байршуулдаг.

Парламентын ил тод байдлыг дэмжих,
иргэдийн хяналтыг сайжруулах
зорилготой сайт юм байна

УИХ-ын гишүүдийн ирц, хөрөнгө, орлого,
намтар, хууль батлахад өгсөн саналын
мэдээлэл, парламентын мэдээ мэдээлэл
гээд олон төрлийн мэдээлэлтэй юм гээч!



УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааныг телевизийн тусгай сувгаар шууд нэвтрүүлэх, түүнчлэн телевиз, радиод тусгай цаг гаргаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг УИХ-ын Тамгын газар зохион байгуулдаг. Мөн парламентын үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр хөгжүүлж буй United Info Hub буюу UIN.mn талбараас холбогдох мэдээллийг авах боломжтой.

Хуулийн этгээдүүдийн
улсын бүртгэлийн
мэдээллийг нягтлах
- Opendatalab.mn

Төсвийн мэдээллийг авах
- Publicinvestment.gov.mn

Шилэн данс хянах
- Shilendans.gov.mn

Төрийн үйл ажиллагааны талаар
мэдээлэл авах өөр олон төрлийн
боломж бий болжээ.



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд төрийн байгууллагуудын нээлттэй байлгах ёстой мэдээллүүдийг заасан байдаг. Тодруулбал, хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж зааснаас бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгах ёстой. Түүнчлэн тус хуулийн дагуу иргэд мэдээлэл авах тухай хүсэлтийг төрийн зохих байгууллагад гаргаж, хуулийн дагуу гаргуулж авах эрхтэй.



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



CFLI/FCIL


Канад сангийн Орон
нутгийн санаачилга

IX. Жендэрийн эрх тэгш байдлын ач холбогдол



Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

Жендэр, жендэр гээд л,
эмэгтэйчүүдийн эрхийн
талаар их ярих юм.
Чи юу гэж бодож байна вэ?



Жендэр бол зөвхөн
эмэгтэйчүүдийн эрхийн асуудал
биш хүйсийн тэгш эрхийн тухай
асуудал юм. Маш буруу
ойлголттой байдаг юм байна, та.



Манай улсад улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл,
оролцоо хангалтгүй болохоор энэ талаар хүмүүс их хөнддөг.
Тиймээс жендэрийг эмэгтэйчүүдийн эрхийн тухай гэж ойлгодог болсон байх.

***“Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал,
гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш
эрхтэй”.***

* "Жендэр" гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ.

Өө тийм үү, тэгвэл бас эрэгтэйчүүдийн эрх хамаарах нь ээ.

Мэдээж шүү дээ. Зарим улсын парламентад эрэгтэйчүүдийн оролцоо багасаж байгааг хөндөж ярьж байна.




Тухайлбал, Монгол Улсын нийт сонгогчдын 51 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг боловч УИХ-ын гишүүдийн 17.3 хувийг л энэ хүйсийн төлөөлөл бүрдүүлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт.

Тиймээс л хүйсийн квот гэж яриад байгаа байх нь ээ.



17.3%

Монгол Улсын иргэн нь төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Гэтэл эмэгтэйчүүдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон нийгмийн тодорхой бүлгийн гишүүдийн сонгогдох эрх хангагдахгүй байгаа учир төрөөс бодлогоор тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.



Квот бол эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоог нэмэх нэг л арга, үүнээс өөр олон арга бий. Ер нь жендэрийн хэвшмэл ойлголтыг халах нь маш чухал.



Хэвшмэл ойлголт гэдэг нь юу юм бол оо?

Эрэгтэй, эсвэл эмэгтэй хүн тийм байх ёстой гэсэн үзлээс л эхэлнэ дээ.



Тэгээд л квотын хувь 2024 онд 30 хувь нь аль нэг хүйс, 2028 оноос 40 хувь нь аль нэг хүйсийнх байна гэж хуульд заажээ.

Жишээ нь, гэр цэвэрлэх, хоол хийх нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хоёулангийнх нь ажил шүү дээ.



Эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг жендэрийн эрх тэгш байдал гэнэ.

Хүйсээс үл хамааран тэгш эрхтэй байх ёстой.



Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар нь ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг жендэрийн ялгаварлан гадуурхалт гэж үздэг.

